

ХЯТАДЫН ЭРДЭМТЭД АЙЛЧИЛАВ

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Олон Улс Судлалын хүрээлэнгийн урилгаар БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн дэргэдэх Хөгжлийн судалгааны төвийн Евро-Азийн нийгмийн хөгжил судлалын хүрээлэнгийн захирал, профессор Чэнь Жихуа тэргүүтэй төлөөлөгчид манай оронд энэ есдүгээр сарын 6-11-ний өдрүүдэд ажлын айлчлал хийв.

Төлөөлөгчид энд байх хугацаандаа УИХ дахь Монгол-Хятадын парламентын бүлэг, Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, Гадаад Хэргийн Яам, Шинжлэх Ухааны Академи, МАХН-ын дэргэдэх судалгааны “Прогноз” төв, Энх тайван Найрамдлын байгууллагуудын Холбооны удирдлагатай нөхөрсөг уулзалт хийж, санал бодлоо солилцов. Мөн олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачидтай дугуй ширээний ярилцлага хийж, Хятад-Оросын харилцаа, Хятад-Төв Азийн улсуудын харилцаа, Хятад-Монголын харилцааны болон бусад сонирхсон асуудлаар харилцан ярилцаж үзэл бодлоо солилцов. Хятадын судлаач Ян Мэйчуань, Жао Юй нар болон академич Б.Балдоо, доктор Д.Шүрхүү, К.Дэмбэрэл, Л.Бэгэжав нар дурьдсан сэдвээр илтгэл тавьж үг хэллээ.

Айлчлалын үеэр Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн захирал, доктор, профессор Лувсангийн Хайсандай, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн дэргэдэх Евро-Азийн нийгмийн хөгжил судлалын хүрээлэнгийн захирал, профессор Чэнь Жихуа нар хоёр хүрээлэнгийн хооронд 2002-2006 онд хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурав.

Уулзалт яриануудад БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Хуан Жякуй болон ЭСЯ-ны дипломат ажилтнууд оролцлоо.

БНХАУ-ын эрдмийн төлөөлөгчдийн ажлын айлчлал ихээхэн үр дүнтэй боллоо гэж хоёр тал санал нэгтэй үзэж байна.

Энэ айлчлал нь Монгол, Хятадын эрдэмтдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, цаашид хоёр тал хамтран ажиллах өргөн бололцоог нээсэн чухал ач холбогдолтой үйл явдал боллоо.